



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2018 оны 06 сарын 26 өдөр

Дугаар 298

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл  
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолын 1.а дахь заалт, “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн 1, 22 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлалтай, Баянголын амны орон сууцны хорооллыг төвлөрсөн дулаан хангамжийн системд холбох дулааны шугам сүлжээний ажлын хүрээнд бий болсон нийт 19,705,710,607.00 (арван есөн тэрбум долоон зуун таван сая долоон зуун арван мянга зургаан зуун долоон) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг “Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга З.Мэндсайхан, “Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч А.Бямбадорж нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Комисс томилон хөрөнгө хүлээн авч бүртгэх ажлыг байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 3 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА

Ц.НЯМ-ОСОР

Б.ГАВАА





Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2018 оны 06 дугаар сарын 16 -ны өдрийн  
292 дугаар тогтоолын хавсралт

"Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц" төрийн өмчит хувьцаат компанийн  
дансанд бүртгэх барилга байгууламжийн жагсаалт

Д/д	Барилга байгууламжийн нэр, байршил	Хөрөнгийн нэр	Барилга		Захиалагч байгууллага	Гүйцэтгэгч байгууллага	Гэрээний дугаар	Улсын комиссын акт дугаар	Төсөвт өртөг (төгрөг)
			Эхэлсэн	Дууссан					
1	Баянголын амны дулааны шугам	Коллектор станц №2- Дулааны худаг /ДХ/ №5 хүртэл дулааны шугам - 1.1 км ф800*10	2012	2014	Эрчим хүчний яам	"Энерго сервис монтаж" ХХК	С-ДШ-Б 2012-138 12/57	2017-11-21 29/2017	2,925,816,183.00
2		Дулааны худаг №26-аас Дулааны худаг №30 хүртэл шугам- 0.2 км ф700*10	2012	2014	Барилга хот байгуулалтын яам	Одкон холдинг ХХК	52/2008	2017-12-18 52/2017	2,999,627,419.00
3		ДХ №5-аас ДХ №13 хүртэл дулааны шугам - 1.35 км ф700*10	2008	2010	Барилга хот байгуулалтын яам	"Мегаватт" ХХК	2007/06	2017-10-24 51/2017	3,009,358,373.00
4		ДХ №13-аас ДХ №26 хүртэл дулааны шугам - 2.9 км ф700*10	2007	2009	Барилга хот байгуулалтын яам	"Мегаватт" ХХК	36/2008		3,971,908,632.00
5		ДХ №30-аас ДХ №40 хүртэл дулааны шугам - 2.3 км ф600*10	2008	2009	Барилга хот байгуулалтын яам	"Тэргүүн инвест" ХХК	2013/007 С-Д5-5 2013-113	2017-11-20 20/2017	6,799,000,000.00
6		ДХ №40-аас ДХ №53 хүртэл дулааны шугам - 5.383 км ф500*10, ф350*8	2013	2015					19,705,710,607.00 (арван есөн тэрбум долоон зуун таван сая долоон зуун арван мянга зургаан зуун долоон)
Нийт дүн									